



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/17/СТА-ТТЗ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	6
2.8.1 Мөнгөн хөрөнгө	6
2.8.2 Авлага	7
2.8.3 Бараа материал	7
2.8.7 Үндсэн хөрөнгө	7
2.8.8 Өр төлбөр.....	8
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо.....	8
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ.....	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч

1. Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
З.МӨНХТӨР ТАНАА

2020.03.23 № 1/345
танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

• 005020276

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Шинэжинст сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч З.Мөнхтөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 13-аас 2020 оны 03 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэв.

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 52 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинэжинст сумын Засаг даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Шинэжинст сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Төрийн аудитын байгууллагаас эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	4	4	-	2	-
2	ТБӨААН	-	-	-	-	-
	Дүн	4	4	-	2	-

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шинэжинст сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Шинэжинст сумын Засаг дарга санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан"" программ хангамж ашигладаг байна.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2344.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 23.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3253.5 сая төгрөгийн 1.0 хувь буюу 32.5 сая төгрөгөөр тооцсон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3, “Хязгаарлалттай” 1 /Эрүүл мэндийн төв/ дүгнэлт өгч, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Соёлын төв, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулж санал дүгнэлт өгөөгүй байна.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайланг санхүүгийн программ гэмтсэн шалтгаанаар Төрийн аудитын байгууллагад 2020 оны 02 дугаар сарын 25-нд ирүүлж Төсвийн тухай хуулийн 8 дугаар 8.9.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 10.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад залрууллаа.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хангамж, бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлыг 4841.0 мянга, Соёлын төвийн үйл ажиллагааны бус зардлыг 5667.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй нэгтгэсэн;

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5.2 сая төгрөгийн залруулга хийлээ.

- Эрүүл мэндийн төвийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийн уялдааг staus программаар шалгаж зөрүүтэй илэрхийлэгдсэн санхүүгийн тайланд үйлчлүүлэгч байгууллагын 2020.02.19 ний өдрийн 18 тоот албан бичгийн дагуу залруулга хийсэн бөгөөд тайлант оны баланст авлага, хөрөнгө, өр төлбөр цэвэр өмч хөрөнгийн зөрүү 5255,9 мянган төгрөгийн залруулга хийсэн.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 209.7 сая, эцсийн үлдэгдэл 251.3 сая төгрөг болж, 41.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-	-
Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө	209.7	251.3	41.6	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-	-
Хадгаламж	-	-	-	-
Дүн	209.7	251.3	41.6	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 251.3 сая төгрөг төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд 78.5 сая, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 13.3 сая, Сум хөгжүүлэх сангийн дансанд 159.5 сая төгрөг байршиж байна.

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 78.5 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь орон нутгийн давсан орлогоос зарцуулагдаагүй, 28.4 сая, төсөвт байгууллагуудын харилцах дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 32.8 сая, урьд оны зарцуулаагүй үлдэгдэл 17.3 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 61.3 сая, эцсийн үлдэгдэл 55.2 сая төгрөг болж, 6.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.4	0.3	-0.1
Байгууллагаас авах авлага	10.0	22.9	12.9
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	-	-	-
Бусад авлага	-	-	-
Зээлийн авлага	50.9	32.0	-18.9
Дүн	61.3	55.2	-6.1

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 2.8 сая төгрөгийн дараах авлага байна.

- Шинэжинст сумын цэцэрлэгийн барилгын зураг төсвийн үнэ 2750.0 мянган төгрөг 2012 онд төлсөн ч барилгын зураг төсөв дахин шинэчлэгдэж шинэ зураг төсвөөр баригдсантай холбоотой тус авлага барагдаагүй байна.

2.8.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 274.3 сая, эцсийн үлдэгдэл 559.1 сая төгрөг болж, 284.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	116.37	118.58	2.21
Эм боох материал	0.17	1.27	1.10
Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	250.00	250.00
Бэлэн бүтээгдэхүүн	30.87	21.99	-8.89
Бичиг хэргийн материал	3.06	3.60	0.54
Аж ахуйн материал	35.24	33.44	-1.80
Сэлбэг хэрэгсэл	0.80	0.80	0.00
Түлш, шатах тослох материал	0.00	0.00	0.00
Хүнсний материал	0.14	0.07	-0.07
Бусад хангамжийн материал	62.22	68.90	6.68
Биологийн хөрөнгө	0.00	0.00	0.00
Мал амьтад	15.44	50.44	35.00
Нөөцийн бараа	10.00	10.00	0.00
Дүн	274.31	559.09	284.77

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд Орон нутгийн хөгжлийн сангаас сумын цэвэрлэх байгууламжийн хөрөнгө оруулалтад олгосон 250.0 сая төгрөгийн хөрөнгийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7386.0 сая, эцсийн үлдэгдэл 7543.5 сая төгрөг болж, 157.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	6,048.49	6,030.96	-17.52
Тээврийн хэрэгсэл	206.20	277.61	71.41
Машин тоног төхөөрөмж	521.69	494.04	-27.65
Тавилга эд хогшил	279.43	279.93	0.50
Батлан хамгаалахын тоног төхөөрөмж	4.93	0.00	-4.93
Түүх соёлын дурсгалт зүйл	1.64	1.64	0.00
Номын фонд	23.95	25.29	1.34
Бусад үндсэн хөрөнгө	119.05	253.39	134.34
Программ хангамж	2.10	2.10	0.00
Бусад биет бус хөрөнгө	178.52	178.52	0.00
Дүн	7,385.99	7,543.48	157.49

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 92.9 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 246.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 74.1 сая төгрөгөөр нэмэгдсэн, балансаас баланст шилжүүлсэн 4.8 сая, акталсан 251.6 сая төгрөгөөр хасагдсан байна.

2.8.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0.5 сая, эцсийн үлдэгдэл 3.9 сая төгрөг болж, 3.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	0.5	3.9	3.4	100.0
Ажилчидтай холбогдсон өглөг	0.4	0.6	0.2	14.7
Байгууллагад төлөх өглөг	0.1	3.3	3.2	85.3
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
Нийт дүн	0.5	3.9	3.4	100.0

Эх сурвалж: Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 3.3 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 0.6 сая төгрөгийн ажилчидтай холбоотой өглөг байгаа ба Сумын цэвэр усны байгууламжийн зураг төсвийн үнэ 2.9 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн тайланд өглөгөөр тусгасан голлох нөлөөг үзүүлж байна.

Хүснэгт 6. Өглөгийн үлдэгдэл байгууллагаар

Байгууллагуудын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс		Зөрүү /өссөн+/ /буурсан-/	Дүнд эзлэх хувь
			Байгууллагад төлөх	Ажиллагсадтай холбоотой		
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.0	0.2	0.2	0.0	0.2	6.0
Засаг даргын Тамгын газар	0.2	0.0	0.0	0.0	-0.2	0.0
Сургууль	0.1	0.1	0.0	0.0	0.0	1.6
Цэцэрлэг	0.0	0.3	0.0	0.3	0.3	7.5
Соёл	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Эрүүл мэндийн төв	0.1	0.4	0.2	0.3	0.3	11.0
Орон нутгийн хөгжлийн сан	0.0	2.9	2.9	0.0	2.9	73.9
Нийт дүн	0.5	3.9	3.3	0.6	3.4	100.0

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6639.0 сая, эцсийн үлдэгдэл 6849.4 сая төгрөг болж, 210.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 7. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6639.0	6849.4	210.4	100.0
Өмч /төрийн/	2422.3	2422.3	0.0	35.4
Хуримтлагдсан үр дүн	2121.4	2333.5	212.1	34.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2095.3	2093.6	-1.7	30.6
Дүн	17,453,752.6	26,972,387.3	9,518,634.7	100.0

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оруулсан капитал данс өөрчлөлт нь тайлант оны хуримтлагдсан үр дүн 212.1 сая төгрөгөөр нэмэгдэж, Эрүүл мэндийн төвийн 6.3 сая төгрөгийн дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой хөрөнгө дахин үнэлгээний нөөц данс 1.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн ИТХ-ын 2019 оны төсөв батлах тухай 14/03 дугаар тогтоолд зааснаар Шинэжинст сумын Засаг дарга тайлант онд улсын төсөвт 6.2 сая, аймгийн төсөвт 168.8 сая нийт 175.0 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 192.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 109.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	6.2	5.2	-1.0	83.5
1.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2.0	2.2	0.2	108.5
1.2.Нэмэгдсэн өртгийн албан татвар	3.0	2.1	-0.9	68.5
1.3.Агаарын бохирдлын төлбөр	1.2	1.0	-0.2	79.5
2.Аймгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого	168.8	187.2	18.4	110.9
2.1.Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	75.0	72.0	-3.0	96.1
2.2.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1.3	1.6	0.3	119.6
2.3.Газрын төлбөр	80.0	99.9	19.9	124.9
2.4.Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12.5	13.7	1.2	109.2
Нийт дүн	175.0	192.4	17.4	109.9

Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1.0 сая төгрөгөөр тасарсан нь нэмэгдсэн өртгийн татвар төлөгчдийн тоо өмнөх оноос буурснаас тус татварын тасарсан, агаарын бохирдлын төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлого төлөвлөгөөнөөс 18.4 сая төгрөгөөр давж биелсэн нь сумын ИТХ-ын тогтоолоор газрын төлбөрийн суурь үнийг шинэчлэн тогтоосонтой холбоотой газрын төлбөрийн орлого давж биелсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2018 оны 03 тоот тогтоолоор сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогыг 53.7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 82.1 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 152.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Сумын орон нутгийн орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.Татварын орлого	49.9	71.7	21.8	143.7
ИОТХ	8.5	15.9	7.4	187.1
Хадгаламжийн хүүгийн орлого	32.0	38.7	6.7	120.8
Бууны татвар	1.1	1.1	0.0	102.0
ҮХЭХ борлуулсны албан татвар	-	5.9	5.9	-
Улсын тэмдэгийн хураамж	1.4	0.8	-0.6	58.0
Ус рашаан	3.3	4.5	1.2	135.4
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	3.0	3.7	0.7	122.3
ТТАМАТ төлбөр	0.3	0.7	0.4	233.3
Нохойны татвар	0.3	0.5	0.2	151.9
2.Татварын бус орлого	3.8	10.3	6.5	272.1
2.1.Хүү торгуулийн орлого	3.8	10.3	6.5	272.1
Нийт дүн	53.7	82.1	28.4	152.8

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 9 хөтөлбөрт зориулан 2568.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1997.7 сая төгрөгийг урсгал зардалд, 570.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 548.5 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 1151.2 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс, 24.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс, 486.6 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 53.7 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс, 194.2 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, 109.3 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс авах санхүүжилт, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг бүрэн авч, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтээс 14.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 18.9 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 95.2 сая төгрөгөөр тасарсан нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлтийн дутуу төвлөрүүлсэн тайлант онд шинээр зээл олгоогүйтэй холбоотой байна.

Туслах үйл ажиллагааны орлого 76.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 3.8 сая төгрөгөөр тасарсан нь Орон нутгийн хөгжлийн сангаас худалдан авсан өвс тэжээлийн борлуулалтын гүйцэтгэлээр төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2327.3 сая төгрөг буюу 90.6 хувьтай байгаа нь сумын Засаг даргын Тамгын газар, Соёлын төвийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 6.3 сая, сургуулийн түлш халаалтын зардал 2.3 сая, Эрүүл мэндийн төвийн тээвэр шатахууны зардал 10.8 сая, эм, эмнэлгийн хэрэгслийн зардал 3.2 сая, Сум хөгжүүлэх сангаас тайлант онд зээл олгоогүйгээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 183.4 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна. шалтгаалсан байна.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар

сая.төг

Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Засаг даргын Тамгын газар	340.0	332.4	7.7	97.7
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	63.1	59.7	3.4	94.7
Ерөнхий боловсролын сургууль	705.3	702.0	3.3	99.5
Цэцэрлэг	242.1	238.8	3.3	98.6
Эрүүл мэндийн төв	382.2	365.9	16.4	95.7
Соёлын төв	80.8	62.7	18.1	77.5
Орон нутгийн хөгжлийн сан	570.6	565.2	5.4	99.0
Сум хөгжүүлэх сан	184.2	0.8	183.4	0.4
Нийт дүн	2568.3	2327.3	241.0	90.6

Хөрөнгө оруулалтын 11 төсөл, арга хэмжээнд 570.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 565.2 сая төгрөгийн санхүүжилт олгож 10.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Төсөвт байгууллагуудын цэвэрлэх байгууламжтай болох" ажил хэрэгжээгүй байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 20.2 сая төгрөгийн нэмэлт бүрдүүлж бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 18.3 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.1 сая төгрөгийг аймгийн төрийн санд 1.8 сая төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Нэмэлт төсвийн судалгаа

Байгууллагын нэр	Санхүүжилт	Зарцуулалт	Төвлөрүүлсэн	
			Аймаг	Сум
Засаг даргын Тамгын газар	3.9	2.6	-	1.3
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	0.5	0.5	-	-
Соёлын төв	1.6	1.0	-	0.5
Эрүүл мэндийн төв	0.0	0.0	-	-
Сургууль	14.2	14.1	0.1	-
Нийт дүн	20.2	18.3	0.1	1.8

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

2.10.1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тайлант онд 250.0 сая төгрөгөөр санхүүжихээр батлагдсан 370.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий "Цэвэр усны байгууламжтай болох" ажилд 265.7 сая төгрөгийн санхүүжилт олгож батлагдсан төсвийг 15.7 сая төгрөгөөр хэтрүүлэн олгож орон нутгийн хөгжлийн санд авлагаар тусгасан байгаа тул тус арга хэмжээний үлдэгдэл төсвийг баталсан эсэхийг тодруулж үзэх.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Шинэжинст сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 90 мэдээллийг хугацаанд нь, 64 мэдээлэлд дахин завсар хийснээс хугацаа хоцроосон төлөвтэй болж 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд сруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	13	13	11		2
2	Хагас жил	3	3	3		
3	Улирал бүр	2	8	5	3	
4	Сар бүр	5	60	42	18	
5	Тухай бүр	6	72	29	43	
	Нийт	29	156	90	64	2

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинэжинст сумын Засаг даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шинэжинст сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайланг санхүүгийн программ гэмтсэн шалтгаанаар Төрийн аудитын байгууллагад 2020 оны 02 дугаар сарын 25-нд ирүүлж Төсвийн тухай хуулийн 8 дугаар 8.9.1 дэх заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл: Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан үнэн зөв нэгтгэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанд төсвийн шууд захирагчийн тайланг гаргаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	545286258.48	865493405.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	209707917.32	251299614.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	209707917.32	251299614.37
3121	Төгрөг	209707917.32	251299614.37
31211	Төрийн сангийн харилцах	209707917.32	251299614.37
33	АВЛАГА	61268402.87	55118184.56
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	418116.07	280018.34
335	Бусад авлага	9985086.80	22863246.22
3351	Байгууллагаас авах авлага	9985086.80	22863246.22
336	Зээлийн авлага	50865200.00	31974920.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	50865200.00	31974920.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	50865200.00	31974920.00
35	БАРАА МАТЕРИАЛ	264309938.29	549075606.93
351	Түүхий эд материал	116543615.00	119850519.00
